

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны хараат болон охин компанид банкнаас оруулсан хувь хөрөнгө буюу хувьцаа эзэмших эрх 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр дуусгавар болно.

2 дугаар зүйл. Банк, банкны үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, банкны төлөөлөн удирдах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, банкны гүйцэтгэх удирдлага Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан бусад этгээд 2018 оны 12 дугаар сарын 31-ний дотор тус хуульд үйл ажиллагаагаа нийцүүлж, энэ талаархи тайланг холбогдох баримтын хамт Монголбанканд 2018 оны 12 дугаар сарын 31-ний дотор ирүүлнэ.

3 дугаар зүйл. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 61, 62, 63 дугаар зүйлд заасан банкны тогтвортжуулалтын санг бүрдүүлэхтэй холбогдсон зохицуулалтыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД